117

# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

# ТОГТООЛ

1959 оны I дүгээр сарын 28-ны өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот

Хотын санхүүгийн хэлтэст тасаг байгуулах тухай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэст түүний батлагдсан орон тоог нэмэгдүүлэхгүйгээр төсвийн тасаг, орлогын тасаг, хянан байцаах тасгийг байгуулсугай.

2. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтсийн эрхлэгчийн сарын үндсэн цалинг 850 төгрөг, тасгийн эрхлэгчийн цалинг 750 төгрөгөөр тогтоосугай.

3. Хотын санхүүгийн хэлтсийн аппаратыг түүнд шаардагдах мэргэжлийн хүмүүсээр хангахыг Сангийн Яамны сайд н.ДҮГЭРСҮРЭН, хотын гүйцэтгэх захиргааны дарга н.БАТЖАРГАЛ нарт үүрэг болгосугай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн I-р орлогч дарга — СҮРЭНЖАВ

Б.Н.М.А.Улсын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга — БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгч /ДАГВАДОРЖ/

Б.Н.М.А.У. ТОГТООЛ АНГИ